- Хоригдлын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах,
- Бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтох эмгэгтэй хоригдлыг албадан эмчлэх,
- Гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирол, төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгаж шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шилжүүлэх, хорих байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх,
- Хуульд заасан бусад чиг үүрэг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоол” батлагдсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.



Тус хаалттай хорих ангийн санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант оны 11 дүгээр сарын 21, 22-ны өдөр хяналт шалгалт хийж, 4 чиглэлээр үүрэг даалгавар өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих анги нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хаалттай хорих анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны А/134 дүгээр тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 723,238.1 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------|----------------|-----------------|--------------------|
| | | | /мянган төгрөгөөр/ |
| | | | |

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|--|--------------------|--------------------|------------------|
| Мөнгөн хөрөнгө | 2,466.7 | 3,767.5 | 1,300.8 |
| Авлага | 13,715.2 | 9,147.6 | (4,567.6) |
| Урьдчилж гарсан зардал | 13,715.2 | - | (13,715.2) |
| Бараа материал | 202,767.7 | 809,852.4 | 607,084.7 |
| Үндсэн хөрөнгө | 6,180,479.8 | 6,313,615.2 | 133,135.4 |
| Нийт хөрөнгө | 6,413,144.6 | 7,136,382.7 | 723,238.1 |
| Өр төлбөр | 2,466.7 | 17,498.5 | 15,031.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 6,410,677.9 | 7,118,884.2 | 708,206.3 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 6,413,144.6 | 7,136,382.7 | 723,238.1 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,767.5 мянган төгрөг болж, 1,300.8 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн 100130412506 дугаар данс 2,289.0 мянган төгрөгийн, хоригдлын нэрийн данс 1,478.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 4,567.6 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны эцэст үүссэн татаас санхүүжилтийн 13,715.2 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулсан болон 9,147.6 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага шинээр үүссэнээс шалтгаалсан байна.

2021 онд эхэлсэн “Гүний худаг гаргах” ажлыг тайлант онд дуусгаж, урьдчилж гарсан зардлын 13,715.2 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө /Тайлант онд татаас санхүүжилтийн авлага 13,715.2 мянган төгрөгийг барагдуулан төсөл, арга хэмжээг нийт 27,430.4 мянган төгрөгийн өртгөөр хэрэгжүүлсэн байна./ -ийн дансанд шилжүүлж бүртгэснээс урьдчилж гарсан зардал данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 809,852.4 мянган төгрөг болж 607,084.7 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:


- Төсвийн хөрөнгөөр 748,293.8 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан,
- Систем хоорондын шилжүүлгээр 384,060.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Малын нас дэвшилт, төлийн 252,155.0 мянган төгрөгийн орлого хүлээн авсан,
- 988,336.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан,
- 338,405.5 мянган төгрөгийн материалыг үйлдвэрлэлд шилжүүлсэн,
- ТӨБЗГ-ын 2022 оны 291 дүгээр тогтоолоор 5,193.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, ШШГЕГ-ын даргын 2022 оны А/273 дугаар тушаалаар 1,060.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг акталсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 7,445,163.9 мянган төгрөг болж 174,990.5 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээтэй холбоотой байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 80,929.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан,
- Систем хоорондын шилжүүлгээр 96,231.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- ТӨБЗГ-ын А-1/2615 дугаар албан бичгийн дагуу 27,430.4 мянган төгрөгийн өртөгтэй гүний худаг, 47,359.3 мянган төгрөгийн өртөгтэй 0.4 кВт-ын агаарын шугамыг ашиглалтад хүлээн авч, орлогод бүртгэсэн,

- ТӨБЗГ-ын 2022 оны 2022 оны 519, 641 дүгээр тогтоолоор 41,719.0 төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан болон 693 дугаар тогтоолоор 163,770.2 мянган төгрөгийн өртөг бүхий 125 хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан гэх мэт.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,031.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст ШШГЕГ-аас 16,020.0 мянган төгрөгийн үнэ бүхий 7 тугалтай 8 үнээг шилжүүлэн авч, систем хооронд өр төлбөр үүсгэснээс шалтгаалсан байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,118,884.2 мянган төгрөг болж 708,206.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих анги нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,499,573.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 293,594.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,793,167.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 288,283.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 39,997.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 34,728.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 339,125.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 168,434.1 төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 96,672.0 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 39,151.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж 1,776,496.1 мянган төгрөгөөр баталсан байна.


3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 40,919.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 38,760.2 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 16,096.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 162,530.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 41,492.1 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 108,945.4 мянган төгрөгөөр гэх мэт нийт 407,844.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,717,308.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 467,031.8 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,717,308.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоор 467,240.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,184,069.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 142.4 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 43.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 82.8 мянган төгрөгөөр гэх мэт батлагдсан төсвийг нийт 271.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.



Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|--------------------|--------------------|--------------|-------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагаа | 1,709,658.8 | 1,709,178.9 | 479.9 | 99.8 |
| 2 | Туслах үйл ажиллагаа | 276,031.8 | 276,240.4 | -208.6 | 100.04 |
| 3 | Шүүхийн шийдвэрийн үйлдвэрлэлийн арга хэмжээ | 191,000.0 | 191,000.0 | - | 100 |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 7,649.9 | 7,649.9 | - | 100 |
| | Нийт | 2,184,340.5 | 2,184,069.2 | 271.3 | 99.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус хаалттай хорих ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд ШШГЕГ-аас төсөл, арга хэмжээний санхүүжилт 47,359.3 мянган төгрөг, иргэн Д.Бат-Оюунаас хандив 2,250.0 мянган төгрөг зэрэг нийт 49,609.3 мянган төгрөгийн орлогууд төвлөрснийг, зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- “Шинээр баригдсан худаг хүртэл төмөр бетон тулгууртай 0.4 кВт-н агаарын шугам барих” ажлын гүйцэтгэгч Зүүнхараа эрчим хүч ХХК-д 47,359.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон,
- Тус бүр нь 900.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг угаалгын машин худалдан авахад 1,800.0 мянган төгрөг,
- Угаалгын машины сэлбэг худалдаж авахад 450.0 мянган төгрөг /*мотор, цагаан араа, ремень авахад 140.0 мянган төгрөг, уртасгагч, перцент, коноп авахад 310.0 мянган төгрөг*/ -ийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын 433 дугаар хаалттай хорих ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/64 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,482,840.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 54,828.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд ХЗДХЯ-аас 2022 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 3/1042, ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 06/1414 дугаар албан бичгээр чиглэл өгсөн бөгөөд тус хаалттай хорих анги нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,*



- Нүүрсний үнэ өмнөх оноос 40 хувиар өссөн хэдий ч бэлтгэн нийлүүлэгчээр шалгарсан Монничикон трейд ХХК-иас 74.6 мянган төгрөгөөр худалдан авч, түлш, халаалтын зардлыг батлагдсан төсөвт багтаасан,
- Дотоод албан томилолтын зардал гаргалгүй ажилласан байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илэрсэнгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих дараах 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 3 удаа,
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг 3 удаа гэх мэт.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь өмнөх аудитаар шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.


Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай “120 тн багтаамжтай төмс, хүнсний ногоо хадгалах зоорь барих” ажлын төсөв, тооцоо, судалгааг мэргэжлийн байгууллагаар бус хорих ангийн эдийн засагч, ахлах нягтлан бодогч гүйцэтгэж 152,946.0 мянган төгрөгийн өртгөөр, аж ахуйн аргаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн

байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь “...барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, гүйцэтгэгчийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.



4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 117,410.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 117,410.1 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, жолоочийн тооцооны хуудсыг автомашин ашигласан албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулаагүй болон шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Тайлант онд 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна. Зөвлөмжийн биелэлт 66.6 хувийн хэрэгжилттэй байна.


Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 117,410.1 | 1 | 117,410.1 | 100 |
| | 1 | - | 1 | - | 100 |
| | 1 | - | - | - | - |
| Нийт дүн | 3 | 117,410.1 | 2 | 117,410.1 | 66.6 |

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд тайлант онд 6 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ШШГЕГ-ын хаалттай хорих 433 дугаар ангийн төсвийн шууд захирагчийн бүс дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газраас өгсөн чиглэлийн дагуу нийт 45,152.5 мянган төгрөгийн үнэтэй уурын зуухны CG 30 маркийн 2 ширхэг бойлерыг БНХАУ-аас худалдаж авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн 2 дахь “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа 20.0 сая төгрөг, Ажил 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. ШШГЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу 12 дугаар сард систем хоорондын тооцоогоор 16,020.0 мянган төгрөгийн үнэ бүхий 7 тугалтай 8 үнээг авч өр төлбөр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчиж байна.

3. Цалингийн зардлаас тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 2,289.0 мянган төгрөгийг төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн 100130412506 дугаар дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ


Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 15,876.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгөв.

5.2 Албан шаардлага

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Тайлант онд иргэн Д.Бат-Оюунаас 3,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер болон нэмэлт санхүүжилтийн дансанд 2,250.0 мянган төгрөгийн хандив авч, зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “Зөвхөн дор дурдсан **нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага** энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.”, 25.2.1:эмнэлгийн үйлчилгээ, 25.2.2: бүх шатны боловсролын үйлчилгээ, 25.2.3:соёлын үйлчилгээ” гэсэн заалтыг зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Хандивын орлого төвлөрүүлж, зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Хувь хүнээс авах 9,147.6 мянган төгрөгийн бүтээгдэхүүн борлуулалтын авлага, 1,478.5 мянган төгрөгийн хоригдлын цалингийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эд хариуцагч нь хүнс, шатахуун, сэлбэг хэрэгсэл, хоригдлуудын ахуйн хангалт зэрэг бараа материалын “Шаардах хуудас”-ыг холбогдох албан тушаалтнаар бус өөрөө бичиж, бараа материалыг зарлагдсан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 3.6 дахь “**Материалын үнэ бүхий зүйлийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.**” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалыг авч зарцуулах хүнээр “Шаардах хуудас”-ыг үйлдүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| | | | | | | | | | | | | |



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|----------|--------------------------------------|-----|---|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хандивын орлого төвлөрүүлж, зарцуулсан. | 1 | 5,250.0 | | | 1 | 5,250.0 | | | | | | |
| Авлага, өр төлбөр үүсгэсэн. | 1 | 10,626.1 | | | 1 | 10,626.1 | | | | | | |
| Бараа материалыг авч зарцуулах хүнээр "Шаардах хуудас"-ыг үйлдүүлээгүй. | 1 | | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 2 | 15,876.1 | | | 2 | 15,876.1 | 1 | - | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|-----|----------|------------------|----------|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | | | | | | 1 | - |
| Дүн | 1 | | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын шинж чанартай зоорины барилгын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй. | 1 | 152,946.0 | | | | | 1 | 152,946.0 | |
| Дүн | 1 | 152,946.0 | | | | | 1 | 152,946.0 | |
| Нийт дүн | 2 | 152,946.0 | | | | | 1 | 152,946.0 | - |